

ЦАХИМ ХИЧЭЭЛД ТАВИГДАХ СЭТГЭЛ ЗҮЙН ШААРДЛАГЫН СУДАЛГАА

(Их дээд сургууль, коллежийн хүрээнд)

Э.Мөнгөнцэцэг¹
¹Дархан Дээд Сургууль

Хүлээн авсан огноо: 2021.10.22

Хэвлэхийн зөвшөөрсөн: Редакцийн зөвлөл, доктор Ц.Нандинсүрэн

Үндэслэл

Аливаа цахим хичээлүүд нь академик шаардлагыг сайтар хангасан байдаг боловч суралцагчдын нийгмийн болон сэтгэл хөдлөлийн чадваруудыг хөгжүүлэх тал дээр дутмаг байдаг. (Albero. B, 2003). Онлайнаар суралцах үед суралцагчид маш хурдан уйддаг бөгөөд өөрийн хяналт доогуур үзүүлэлттэй байгаа нь тогтоогдсон. (Wang et al., 2020) Онлайн хичээлийн үеийн нийгэм сэтгэл хөдлөлийн харилцаа дутмаг, амьд харилцаа үүсгэх боломжгүй байдал нь суралцагчдыг анхаарал төвлөрөх чадвар сул, сэтгэл хөдлөлийн хувьд тааламжгүй болгодог байна. (Yin-xia et al., 2005) Дээрх эрдэмтдийн судалгааны үр дүнгээс харахад бид цахим хичээлд тавигдах сэтгэл зүйн шаардлагыг судлан цахим хичээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага үүсч байна.

Түлхүүр үгс: Цахим хичээл, хичээлд тавигдах сэтгэл зүйн шаардлага, суралцагчид

Зорилго, зорилт

Цахим хичээлд тавигдах сэтгэл зүйн шаардлагыг судлах зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлээ.

- Цахим хичээлд тавигдах сэтгэл зүйн шаардлагыг онолын түвшинд судлах
- Цахим хичээлд тавигдах сэтгэл зүйн шаардлагын талаарх судалгаа хийх

Судалгааны арга зүй

Судалгааны объект: Цахимаар суралцагчид

Хамрах хүрээ: ДУА-ийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежууд

Таамаглал: Цахим хичээл нь хичээлд тавигдах сэтгэл зүйн зарим шаардлагад нийцэхгүй.

Түүврийн хэмжээ: Санамсаргүй түүврийн аргаар нийт судлуулагчдын 10%-ийг хамруулах (2936 сурагчдын 10%=293 түүнээс дээш)

Судалгааны арга, аргачлал: Асуулгын арга (нээлттэй асуулга болон анкет)

Судлагдсан байдал:

- 2009 онд Р.Ченг (Cheng. R), П. Жонс (Jones. P) нар “онлайнаар суралцагч оюутнуудын ангийн виртуал орон зай” хэмээх илтгэлээ олон улсын нээлттэй судалгааны нийгэмд хэлэлцүүлсэн.
- 2014 онд судлаач Ж.Лэйзер (Iazar. G) болон Недеф (Nedeff) нар “онлайн сургалтын үйл ажиллагааны үр ашигтай байдалд SWOT шинжилгээ” хэмээх судалгааны ажил хийсэн.
- Цахим мэдлэг ТББ нь 2017 онд “монгол дахь онлайн сургалтын хэрэгцээ, шаардлага, зах зээлийн судалгаа”-г хийсэн.
- 2013 онд ШУТИС-ийн судлаач Ж.Алимаа “онлайн сургалтын агуулга хөгжүүлэх арга зүйн судалгаа” диссертацийн ажил хэвлүүлсэн.

Судалгааны ажлын шинэлэг тал:

Олон судлаачид “Онлайн сургалтын үр дүнг сайжруулах” талаар төрөл бүрийн судалгааны ажил хийсэн байдаг. Гэвч нийтлэг судалгааны ажлууд нь сэтгэл зүйн асуудлуудыг төдийлөн нарийвчлан судлаагүй байгаа нь ажиглагдсан. Тиймээс уг судалгааны ажил нь “**цахим хичээлд тавигдах сэтгэл зүйн шаардлага**”-ыг онцгойлон авч үзэж буйгаараа онцлог болно.

Нэгдүгээр бүлэг. Цахим хичээл, түүнд тавигдах сэтгэл зүйн шаардлагын талаарх онолын судалгаа

Цахим хичээл гэдэг нь хичээлийн багц материалыг суралцагчдад цаг хугацаа, орон зайнаас үл хамааруулан, мэдээллийн технологийг ашиглан бие даан судлах боломжтой болгон зохиомжлон бэлтгэсэн хичээл. (**МУИС-ийн цахим сургалтын түр журам**)

Судлаач Б.Тэгшжаргалын “Багшлахуйн менежмент” хэмээх бүтээлд хичээлд тавигдах сэтгэл зүйн шаардлагыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Сурагчдад сурах сэдэл, хүсэл, тэмүүлэл, сонирхол бий болгох, хичээлд хандах эерэг хандлагыг төлөвшүүлэх

Багшийн сургах арга, хэрэглүүр, дасгал бодлого нь сурагчдын сурах чадвар, нас, сэтгэхүйн онцлогт тохирсон байх

Сурагчдын идэвхи санаачлагыг дэмжиж, сурч танин мэдэх төрөл бүрийн бүтээлч үйл ажиллагаанд татан оролцуулах

Багш хичээл дээр сэтгэл зүйн таатай уур

амьсгал бүрдүүлэх

Сурагчдад бие хүний эрхэм сайн чанаруудыг хөгжүүлэн төлөвшүүлэх

Суралцагч гэдэг нь мэдлэг олж авах, мэргэжил эзэмших, ямар нэгэн салбар шинжлэх ухаанд мэргэших зорилгоор аливаа боловсрол, сургалтын үйл ажиллагаанд хамрагдсан хүн мөн. (Англи хэлний толь бичиг)

М.Монтессорийн сургалтын арга зүйд үндэслэн боловсруулсан цахим хичээлд тавигдах сэтгэл зүйн шаардлага

(Marcella Bernhard, 2014)

Цахим сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан суралцагчдын нийгэм- сэтгэл хөдлөлийн болон танин мэдэхүйн чадваруудыг хөгжүүлэх бүрэн боломжтой. Үүнийг хэрэгжүүлэх үр дүнтэй сургалтын арга зүйн нэг хэсэг нь “Мария Монтессорийн сургалтын арга зүйд үндэслэсэн сургалт” болно. М.Монтессорийн сургалтын арга зүй нь бага насны хүүхэдтэй ажиллахад өргөн хэрэглэгддэг боловч түүний бүтээсэн “Хүрээлэн буй орчноос суралцах” зарчим нь онлайн орчинд дээд боловсрол эзэмшиж буй насанд хүрэгчдэд илүү тохиромжтой. М.Монтессорийн хүрээлэн буй орчноос суралцах зарчим нь дараах бүтэцтэй байна. **Үүнд:** Эмх цэгц ба дэс дараалал, эрх чөлөө, гоо зүй, бодит байдал ба байгаль, харилцаа, бүтээлч оюун ухаан

Эмх цэгц: Цахим хичээл нь маш сайн зохион байгуулалттай, ойлгомжтой, шилжилтийг урьдчилан таамаглаж болохуйц байдаг учраас суралцагчдад амжилттай суралцах итгэлийг буй болгодог.

Бүтээлч оюун ухаан: Цахим хичээл нь суралцагчдад оюун ухааны олон төрлийн бүтээлч үйлийг хийх боломжийг олгодог. Жишээлбэл: өөрийн хүрээлэн буй орчинд ажиглалт хийх, лабораторын орчноос илүү бодит байгальд туршилт хийх гэх мэт.

Эрх чөлөө: Насанд хүрэгчид нь сонголт хийх боломжтой чөлөөт нөхцөл байдалд суралцах илүү сонирхолтой байдаг. Учир нь энэхүү нөхцөл байдал нь тэдний бие даасан байдлыг бататгаж өөрийн үйл ажиллагаагаар дамжуулан идэвхтэй суралцах боломжийг олгодог.

Гоо зүй: Суралцагчид ерөнхийдөө зурган мэдээллийг хүртэн хүлээн авахдаа эерэг сэтгэл хөдлөлтэй буюу тааламжтай байдаг. Маш нухацтайгаар сонгосон, үзэмжтэй, гоё сайхан зургууд нь сурагчдын сурах сэдэл, сонирхлыг өдөөж өгөх болно.

Бодит байдал, байгаль: Цахим хичээлийн явцад багш тухайн бичлэгийг үргэлжлүүлэн унших (эцэс төгсгөлгүй), асуулт-хариулт бүхий хэлэлцүүлэг өрнүүлэх нь суралцагчийг хүндрэлтэй байдалд оруулдаг. Түүнчлэн эдгээр үйл явц нь онлайн сургалтыг танхимын сургалтаас эрс ялгаатай, бодит байдлын эсрэг үйл ажиллагаа

болгодог.

Харилцаа: Суралцагч онлайн орчинд хичээллэж байх үед санаандгүй тохиолдлоор бусад суралцагчидтай харилцаа үүсгэдэггүй. Тиймээс ганцаарчлан болон багаар ажиллах, виртуал хурал хийх, нийгмийн харилцаа буй болгох арга техникийг ашиглах зэргээр хичээлийн явцад “суралцагч-суралцагч” хооронд, “багш-суралцагч” хооронд гэх мэт дарааллаар ангийг удирдан чиглүүлж, зохион байгуулах нь зүйтэй.

Хоёрдугаар бүлэг. Цахим хичээлд тавигдах сэтгэл зүйн шаардлагыг судласан судалгааны үр дүн

Судалгааны үйл явц, үр дүн:

Бидний энэхүү судалгаанд Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн 5 их, дээд сургууль болон коллежийн 18-45 насны нийт 314 суралцагчид хамрагдсан. Судлуулагчдын хувьд 288 эмэгтэй, 26 нь эрэгтэй байсан бөгөөд I-V курс болон эчнээ ангийн суралцагчид хамрагджээ.

Судалгааны асуулгын эхэн хэсэгт суралцагчдын цахим хичээлд хамрагддаг эсэх, түүнийг хүлээн авч буй хэлбэр, ашигладаг платформыг тодруулсан. Үүнд:

Нийт суралцагчдын 72% нь тогтмол буюу өдөр бүр, 28% нь заримдаа буюу танхимын сургалттай хосолсон хэлбэрийн цахим хичээлд хамрагддаг байна. Мөн суралцагчид цахим хичээлээ Google meet, Zoom, Moodle, Facebook гэх мэт платформуудыг ашиглан хүлээн авдаг бөгөөд нийт суралцагчдын 54.1% буюу 170 нь classroom платформыг ашиглан хичээлээ хүлээн авч байгаа нь анхаарал татсан тоон үзүүлэлт юм. Нийт судлуулагчдын 110 нь буюу 35% нь power point presentation, 130 нь буюу 41% нь media хэлбэрээр (дүрс дуу, бүхий бичлэг), 48 нь буюу 15.3% нь PDF, 26 нь буюу 8.3% нь бусад хэлбэрээр бэлтгэсэн цахим хичээлийг хүлээн авдаг байна.

Сурагчдын сурах сонирхол, хүсэл эрмэлзлэлийн хувьд нийт суралцагчдын 42% нь тухайн хичээлийн агуулга, багшаас хамааран өөр байдаг гэж үзжээ. /mean=2.13, median=2.0, mode=2 /Энэ суралцагчдын сурах сонирхол, хүсэл эрмэлзэл тухайн хичээлийн агуулга, багшаас хамааран харилцан адилгүй байгааг бататган харуулж байна. Түүнчлэн нийт судлуулагчийн 54,8 % нь цахим хичээлийн үед анги хамт олны сэтгэл зүйн уур амьсгалын талаар мэдэж чаддаггүй байна. / mean=2.12, median=3.0, mode=3/ Эндээс цахим хичээлийн үед нийгэм, сэтгэл хөдлөлийн харилцаа үүсгэх боломж хязгаарлагдмал байгааг харж болно. Цахимаар суралцах хугацаанд нийт суралцагчдын 48.4% нь бие даан суралцах чадвар сайжирсан, 16.6% нь цагийн менежмент сайжирсан, 28 % нь огт өөрчлөлт гараагүй хэмээн дүгнэжээ. /Mean=2.46, median=2.0, mode=1/ Иймд цахим хичээлийн явцад суралцагчдад ямар эерэг өөрчлөлт гарах нь тухайн суралцагчаас хамааран

өөр өөр байна. /St Deviation=1.7/


Түүнчлэн цахимаар суралцах үед суралцагчдад гарсан сөрөг өөрчлөлтийн хувьд 28.7% нь сурах идэвхи буурсан, 21.7% нь анхаарал төвлөрөх чадвар суларсан, мөн 28% нь сөрөг өөрчлөлт гараагүй хэмээн үзжээ. /Mean=2.90, median=2.0, mode=1/ Үүнээс үзэхэд цахим хичээлийн үед суралцагчдад гарах сөрөг өөрчлөлт нь тухайн суралцагчаасаа хамааран өөр өөр байх /St Deviation=1.6/ боловч тэдний сурах идэвхи буурах, анхаарал төвлөрөх чадвар сулрах гэх мэт сөрөг илрэлүүд буй болох магадлалтайг илэрхийлнэ.

Корреляцийн анализ:

Цахим хичээлд тавигдах сэтгэл зүйн шаардлага нь $P=0.05$ түвшинд авч үзэхэд $P=0.010<0.18$ (Asymp Sig/-tailed=0.010) буюу суралцагчдын сурах сонирхол, хүсэл эрмэлзлэлтэй сул хамааралтай байна. Анги хамт олны сэтгэл зүйн уур амьсгал нь $P=0.05$ түвшинд авч үзэхэд $P=0.010<0.39$ (Asymp Sig/-tailed=0.010) сурагчдын сурах сонирхол, хүсэл эрмэлзлэлтэй сул хамааралтай.

Судлуулагчдаас цахим хичээлд тавигдах сэтгэл зүйн шаардлагуудаас аль шаардлагыг бусдаас илүү чухалчилж үзэхийг тодруулахад суралцагч бүрийн хувьд харилцан адилгүй байсан боловч цахим хичээл нь эрх чөлөө болон сонголт хийх боломж, эмх цэгц, зохион байгуулалт, харилцаа үүсгэх боломжийг нэн түрүүнд хангасан байх шаардлагатай байна.

График. 1 Цахим хичээлд тавигдах сэтгэл зүйн шаардлага



Дүгнэлт

“Цахим хичээлд тавигдах сэтгэл зүйн шаардлага”-ыг тодорхойлох зорилго бүхий энэхүү судалгааны ажлын хүрээнд судлаач дараах дүгнэлтэнд хүрэв. **Үүнд:**

Харилцаа үүсгэх боломжтой, эмх цэгцтэй, зохион байгуулалттай, эрх чөлөө буюу сонголт хийх боломжтой байх нь цахим хичээлд тавигдах нэн тэргүүний шаардлага мөн. Цахим хичээлийн явцад суралцагчид анги хамт олны сэтгэл зүйн талаар ямар ч төсөөлөлгүй байгаа нь багш, суралцагчид хоорондын нийгэм сэтгэл хөдлөлийн харилцаа үүсгэх боломжийг хязгаарлаж байна. Түүнчлэн суралцагчийн бие хүний хөгжил төлөвшилд эерэг эсвэл сөрөг өөрчлөлт гарах эсэх нь тухайн суралцагчаас өөрөөс нь шалтгаалах хүчин зүйл юм. Хичээлд тавигдах сэтгэл зүйн

шаардлагыг зөв тодорхойлж чадвал цахимаар суралцагчдын сурах сонирхол, хүсэл эрмэлзлэлд эерэг нөлөөтэй.

Abstract:

E-learning is inevitable learning method and the significant part of curriculum at university and college. However, during E-learning, it might be impossible to meet some qualification for psychological standards of lessons, which it has decreased results of learning.

Therefore, the studies described in this paper sought to investigate standards and qualification of e-learning at universities and colleges of Darkhan-Uul province.

As a result, we found three significant psychological qualifications of online learning of university and college, namely, freedom, order and organization, and verbal and nonverbal communication.

Ном зүй:

Монгол хэл дээрх ном зүй:

1. Тэгшжаргал Б.Багшлахуйн менежмент. 2 дахь хэвлэл, соёмбо принт; 2014.
2. Дэлгэржав М. Сурган хүмүүжүүлэх сэтгэл судлал. Соёмбо принт; 2011.

Гадаад хэл дээрх ном зүй: Эрдэм шинжилгээний өгүүлэл

1. Bradford, G., Wyatt, S. (2010) Online learning and student satisfaction: Academic standing, ethnicity and their influence on facilitated learning, engagement, and information fluency. The Internet and Higher Education 13(3): 108–114.
2. Appleton, J. J., Christenson, S. L., Kim, D., Reschly, A. L. (2006) Measuring cognitive and psychological engagement: Validation of the student engagement instrument. Journal of School Psychology 44: 427–445.

• Ашигласан цахим эх сурвалж (Веб сайт)

1. МУИС. МУИС-ийн цахим сургалтын түр журам. 2020.04.20. <https://www.num.edu.mn/>
2. ШУТИС.Цахим сургалтын үйл ажиллагааг зохицуулах түр журам.2020.04.01. https://www.must.edu.mn/media/uploads/2020/04/24/tsahim_juram.pdf
3. Andi Wahyu Irawan, Dwisona Dwisona, Mardi Lestari. Psychological Impacts of Students on Online Learning During the Pandemic COVID-19.2020.02.13. <http://ejournal.radenintan.ac.id/index.php/konseli/article/view/6389>